



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/96

Улаанбаатар хот

Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" 487 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт", 7 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт", Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн "Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" 32 дугаар тушаал, 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн "Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тооны дээд хязгаарыг шинэчлэн баталсугай.

2. "Аймаг дахь стандарт, хэмжил зүйн хэлтсийн албан тушаалын ангилал, зэрэглэл"-ийг 1 дүгээр хавсралт, "Архангай аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 2 дугаар хавсралт, "Баян-Өлгий аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 3 дугаар хавсралт, "Баянхонгор аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 4 дүгээр хавсралт, "Булган аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 5 дугаар хавсралт, "Говь-Алтай аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 6 дугаар хавсралт, "Говь-Сүмбэр аймаг дахь аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 7 дугаар хавсралт, "Дархан-Уул аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 8 дугаар хавсралт, "Дорноговь аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 9 дүгээр хавсралт, "Дорнод аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 10 дугаар хавсралт, "Дундговь аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 11 дүгээр хавсралт, "Завхан аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 12 дугаар хавсралт, "Орхон аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 13 дугаар хавсралт, "Өвөрхангай аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 14 дүгээр хавсралт, "Өмнөговь аймаг дахь

13221491

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 15 дугаар хавсралт, "Сүхбаатар аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 16 дугаар хавсралт, "Сэлэнгэ аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 17 дугаар хавсралт, "Төв аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 18 дугаар хавсралт, "Увс аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 19 дүгээр хавсралт, "Ховд аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 20 дугаар хавсралт, "Хөвсгөл аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 21 дугаар хавсралт, "Хэнтий аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар"-ыг 22 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

3. Албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт орсон, шинээр нэмэгдсэн чиг үүргийн хүрээнд бий болсон албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан батлуулахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Ууганбаяр), хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Хэлтэс бүр 2024 оны эхний хагас жилд багтаан ажлын байр, өмч хамгаалах ажлыг гэрээт харуул хамгаалалтын байгууллагаар гүйцэтгүүлэх талаар зохих арга хэмжээ авч, хэрэгжилтийг тайлагнахыг аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Харуул хамгаалалтын зардлын төсвийн төсөл, судалгааг тухайн оны 11 дүгээр сарын 15-ны дотор ирүүлж байхыг аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах, зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Б.Ууганбаяр), Санхүүгийн хэлтэс (О.Оюунтуяа) -т тус тус даалгасугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн "Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн албан тушаалын ангилал, зэрэглэл, дотоод зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" А/36 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.БАТБААТАР

Стандарт, хэмжил зүйн газрын даргын
 2024 оны 04 дугаар сарын 26 өдрийн
 А/96 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЙМАГ ДАХЬ СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН АЛБАН ТУШААЛЫН
 АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын зэрэглэл	Албан тушаалын ангилал
1	Хэлтсийн дарга	ТЗ-4	Ахлах түшмэл
2	Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч	ТЗ-7	Дэс түшмэл
3	Сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд Ахлах мэргэжилтэн /Хүний нөөц, дотоод хяналтын асуудал хариуцсан/	ТЗ-7	
4	Бүтээгдэхүүн, баталгаажуулалтын мэргэжилтэн	ТЗ-9	
5	Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтэн	ТЗ-9	
6	Мэргэжилтэн /Сургалт, мэдээлэл, салбар сан/	ТЗ-9	
7	Ахлах нягтлан бодогч	ТҮМ-7	
8	Лабораторийн эрхлэгч	ТҮМ-6	
9	Техникч	ТҮ-5	
10	Бүтээгдэхүүн баталгаажуулалтын ажилтан /Халал/	ТҮ-6	
11	Сорьц тогтоох лабораторийн химич-шинжээч	ТҮМ-5	
12	Лабораторийн шинжээч, дээж хүлээн авагч /химич, микробиологи, хорио цээр/	ТҮМ-4	
13	Сорьц тогтоох лабораторийн үнэт металл хайлагч	ТҮМ-4	
14	Архив, бичиг хэргийн ажилтан /нярав/	ТҮМ-3	
15	Лабораторийн лаборант /шил угаагч/	ТҮМ-3	
16	Жолооч	ТҮ-3	
17	Үйлчлэгч	ТҮ-1	